



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2016 оны 12 сарын 13 өдөр

Дугаар А/588

Мөрөн

Зөвлөх үйлчилгээ, сургалтын зардлын
санхүүжилт олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.6-гийн "а" дахь, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолын 3.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажил үйлчилгээний гүйцэтгэлд хийсэн дотоод аудитын хүрээнд гарсан зардлын 3296.0 мянган төгрөгийн төсөвт зардлыг захиалагчийн хяналтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/-д зөвшөөрсүгэй.

2. Уг зардлаар гүйцэтгэсэн ажлын үр дүнг тооцож, зөрчлийг арилгаж ажиллахыг аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга /В.Нэргүй/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД